ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016.12.23 Улаанбаатар хот

Нэг: Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн

1. Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлж, алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах гэсэн нэгдүгээр зорилтын хүрээнд:

Цагдаагийн газрын удирдлагаас 2016 онд цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд ахлахаас дээш удирдах ажилтны ажлын хариуцлага, хүнтэй ажиллах ур чадвар, өөрийгөө хөгжүүлэх, манлайллыг өндөрсгөх, цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт, хууль, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажлын байрны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллахад гол зорилтоо дэвшүүлсэн.

Гэмт хэрэгтэй тэмцэх, Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг ханган ажиллахдаа өмнөх оны ажлын тайлан, тоон үзүүлэлтэндээ дүн шинжилгээ хийж, байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн ээлжит 1 дүгээр хуралдаанаар гэмт хэргийн зөрчлийн мэдээ тайлан, байгууллагын хяналт, шинжилгээ, хэрэглэгчийн үнэлгээний тайлангийн талаар хэлэлцэн, 2015 оны ололт, амжилт, алдаа дутагдлаа цэгнэн цаашид хийх ажлаа төлөвлөсөн.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас удаа дараа ирж байгаа үүрэг ажлын чиглэлд алба хаагчийн харилцаа хандлага, сахилга хариуцлага өнөөгийн тавигдаж байгаа шаардлагад хүрэхгүй байгаа талаар дурдан үүнд удирдлагаас тавих хяналт сул ажлын шалгуур үзүүлэлтэнд сахилга ёс зүйг оруулан дүгнэхгүй байгаа талаар дутагдалтай хандсан байдаг. Энэ дагуу удирдлагаас алба хаагч нарын ажлыг дүгнэж байгаа ЦБҮАЖын код 111 –ийн хүрээнд гарсан ажлын мэдээнд сахилга ёс зүйн талаар ажлын үзүүлэлт нэмж оруулан, алба хаагчийг дэвшүүлэх, албан тушаалын цол олгуулах, дээд газрын шагналд тодорхойлохдоо гол шалгуураа болгож ирлээ.

Тус цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газраас 2016 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус цагдаагийн газарт хэрэгжүүлэх 26-н ажил, өөрийн байгууллагын ажлын онцлогтой уялдуулан 42-н ажил, цагдаагийн байгууллагын стратегийн зорилтын хүрээнд 6 бүлэг, 68 заалттай ажлыг төлөвлөж ЦЕГ-ын дэд даргаар батлуулан биелэлт үр дүнг тооцон ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингисийн удирдах ажилтны зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, сахилга хариуцлага удирдлагын манлайллыг сайжруулах, талаар тэргүүн дэд болон дэд дарга нараас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлүүдийг тасгуудын үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан төлөвлөж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх 2016 оны үйл ажиллагааны салбар төлөвлөгөөг 8 бүлэг 16 заалттай гарган хэрэгжүүлж, биелэлт үр дүнг 2016 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тооцон хүргүүллээ. Авлигатай тэмцэх газрын 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдөр 03/7859 тоотоор цагдаагийн байгууллагад ирүүлсэн зөвлөмж, Цагдаагийн байгууллагын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх газраас өгсөн үнэлгээний дүн болон төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх мониторингийн судалгааны тайланг алба хаагчдад танилцуулсан.

Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд орон тооны бус ажлын хэсгийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, 2016 онд ажиллах 7 бүлэг, 35 заалт бүхий төлөвлөгөөг 2016 оны 01-р сарын 25-ны өдөр батлан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.

Байгууллагын соёл, алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах гэсэн хоёрдугаар зорилтын хүрээнд:

Тус цагдаагийн газраас 2015 онд сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын зөрчлийн байдалд үнэлэлт өгч, тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодохгүй, албан үүрэг гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авахгүй байх баталгааг гаргуулан авч, харилцаа хандлагыг сайжруулах талаар *газрын* сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос нь

- “Бие хүний сэтгэл зүйн онцлогийг харгалзан харилцах нь”
- “Харилцаанд сөргөөр нөлөөлөх 23 биеийн хөдөлгөөн ба өөртөө итгэлтэй болох энгийн 8 арга”
- “Утсаар ярих харилцааны сэтгэл зүйн онцлог” сэдвээр
- “Цэргийн нөхөрлөл” ОУБ-ын сургагч багш, доктор, профессор Виктор Салазар “Харилцах ур чадвар, сэтгэл зүйн бэлтгэл” сэдвээр тус тус танхимын сургалт оржээ.

Түүнчлэн алба хаагчдыг *архи согтууруулах ундааны хор уршиг, гарах сөрөг үр дагаврааас сэрэмжлүүлэх зорилгоор* ХЗЯ-ны харъяа Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран “Архины хор уршиг, хөнөөл” сургалтыг зохион байгуулан Хууль зүйн яамнаас гаргасан цуврал баримтат сургалтын материалаар 6 удаа сургалт орсон байна.

Алба хаагчдад *эерэг хандлага, зөв дадал төлөвшүүлэх зорилгоор* СЭМҮТ-ийн эмч Ж.Гантулга “Эерэг хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх нь”, Эрдэнэзуу хийдийн хамба лам Н.Баасансүрэн “Хайрлахуй ба зав хандлагатай байх нь”, хувь хүн, байгууллагын соёлыг дээшлүүлэх зорилгоор “Төрийн албаны шинэчлэлийн үе дэх харилцаа, хувцаслалт, хувийн соёл” сэдвээр Леди төвийн захирал Р.Лхагвадулам, “Аз жаргалыг өөртөө бий болгох, аз жаргалтай гэр бүл орших нь “ сэдвээр гэр бүл судлаач Б.Нарантуяа, Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулав.

Мөн ЦЕГ-аас зохион байгуулсан сахилга ёс зүйн зорилтот сургалтанд:

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон болон архи согтууруулах ундаа хэрэглэн сахилга ёс зүйн зөрчил гарган сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын давтан сургалтанд 6 алба хаагч
- Харилцаа ёс зүйн зөрчил гарган сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын давтан сургалтанд 3 алба хаагч хамрагджээ.

2016 онд 12 зөрчилд 9 офицер, 6 ахлагч нийт 15 аолба хаагч сахилгын шийтгэл хүлээсэн ба урьд оноос 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Газрын алба хаагчдын харилцааны соёлд онцгой анхаарч, иргэдтэй соёлч, албаны нэр хүндийг өндөрт өргөн харилцаа хандлагаа сайжруулж байгууллагын соёлыг түгээж ажиллахаар салбар төлөвлөгөөг гарган тодорхой ажлуудыг шат дараатай хийж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 31 ны өдрийн А/127 тоот тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд “Сахилга ёс зүйг сайжруулах дэд хөтөлбөр” батлагдсаныг танилцуулж, газрын хэмжээнд сахилга хариуцлагыг сайжруулах 20 заалттай төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэнд хяналт тавьж ирлээ.

Дээд газраас ирүүлсэн алба хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах талаар ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг Мягмар, Пүрэв гарагийн мэдээллийн цагаар алба хаагчдад мэдээлж, хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөөг тухай бүрт нь гарган биелэлтийг дүгнэж ирсэн.

Сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргасан 8 алба хаагчтай шалтгаан нөхцлийг тогтоох, сэтгэл зүйн хямрал, гутрал байсан эсэх талаар болон тайвшруулах ярилцлага хийн, мэдээлэл хийх хуваарь, сэдвийн хамт өгөн 2 алба хаагч мэдээлэл хийн, 4 алба хаагчийн сэтгэл зүйн дүгнэлтийг гарган холбогдох ажилтанд өгөв.
Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдаас цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Н.Ариунболд “Цагдаагийн байгууллагын эргүүл харуулын дүрэм”, цагдаагийн ахлах ахлагч М.Мөнх-Эрдэнэ “Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний стандарт” сэдвүүдээр тус тус сургалт орсон байна.

Газрын нийт бие бүрэлдэхүүний 60 хувийг бүрдүүлдэг ахлагч бүрэлдэхүүний сахилга, хариуцлага, ажлын үр дүн, хамт олны нэгдмэл уур амьсгалыг бүрдүүлэх, албаны бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор “Ахлагчийн зөвлөл”-ийг байгуулан дүрэм, ажлын төлөвлөгөөг батлан үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Байгууллагын соёл нь зөвхөн алба хаагч нарын харилцаа хандлага, сахилга ёс зүйгээс гадна, харилцах байгууллагууд рүү хүргүүлж байгаа албан бичгийн төлөвлөлт, иргэд байгууллагад хүргэж байгаа үйлчилгээний стандарт, соёлыг түгээх олон талт ажиллагаа болон, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах байдаг тул, сурталчлах аяныг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллаа.

Цагдаагийн алба хаагчийн албаны бэлэн байдал, онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадвар, тусгай хэрэгсэл агсамж, биеийн хүч хэрэглэх чадварыг олгох дадлагажуулах, Улсын их баяр нааам, Ази Европын дээд шатны 11 дүгээр уулзалтын хамгаалалтанд бэлтгэх үүднээс 2016 онд албаны бэлтгэлийн хичээлийг 1 удаа, бэлэн байдлыг 3 удаа шалгаж зааварчилсан. Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, дэд комиссар Ц.Ням-Очироос ирүүлсэн үүргийн дагуу Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойн хүрээнд цагдаагийн байгууллагад эерэг соёлыг бүрдүүлж, төлөвшүүлэхэд дэмжлэг болох, дүрэм журмыг мөрдүүлж алба хаагчид хэрхэн биеэ авч явах, харилцахыг хэвшүүлэх замаар соёлд суралцуулах, байгууллагын хөгжлийн түүх, түүний цаашдын чиг хандлага, удирдлагын бодлого, үйл ажиллагааг танин мэдэх эх сурвалжийг баяжуулах зорилго бүхий “Байгууллага, алба хаагчийн соёлыг дээшлүүлье” аяны удирдамжийг алба хаагчдад танилцуулан дээрх аяны хүрээнд Төмөр зам дахь Цагдаагийн хэлтэст аяныг зохион явуулах салбар удирдамж, төлөвлөгөөг гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

2. Сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх гэсэн гуравдугаар зорилтын хүрээнд:

Тус газрын 2016 оны албаны сургалтыг ЦЕГ-ын даргын 2016 оны б/106 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын 2016 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”, б/257 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын сургалтын хөтөлбөр 2016-2019”, ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын 2015.11.30-ны өдөр баталсан “Цахим сургалтын удирдамж”, Цагдаагийн байгууллагаас Эрх зүйн сургалт сурталт, сурталчилгааны чиглэлээр 2016 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, Төмөр зам дахь цагдаагийн газрын даргын баталсан газрын 2016 албаны сургалтын төлөвлөгөөг удирдлага болгон зохион байгууллаа.

Тус газрын танхимын сургалтыг дараахь 4 үндсэн чиглэлээр зохион байгуулсан бөгөөд

- Алба хаагчийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг 27 удаа 54 цаг 2446 алба хаагч
- Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 20 удаа 40 цаг 1489 алба хаагч
- Мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах сургалтыг 23 удаа 46 цаг 1702 алба хаагч
- Бие бялдрын бэлтгэлжилтийн сургалтанд давхардсан тоогоор 2777 алба хаагч хамрагдсан байна.

Ажлын байран дээрх танхимын сургалтанд аудио бичлэг 10 удаа ашиглаж, сургалтын зохиомол орчинг 2 удаа бүрдүүлсэн бөгөөд сургагч багш болон тасгийн даргаас дээшхи албан тушаалтан 15 удаа сургалт орж 1474 алба хаагч хамрагджээ.

2016 онд тус газрын алба хаагчдаас

- ✓ 11 алба хаагч ХСИС-ийн эчнээ ангид,
- ✓ 2 алба хаагч магистрын сургалтанд,
- ✓ 1 алба хаагч англи хэлний дунд шатны сургалтанд
- ✓ 1 алба хаагч англи хэлний гүнзгийрүүлсэн шатны сургалтанд
- ✓ 35 алба хаагч албан тушаалын сургалтанд
- ✓ 166 алба хаагч бусад зорилтот сургалтанд тус тус хамрагдаж хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч О.Өсөхбаяр “Хууль зүйн ухаан магистр” зэрэгтэй болжээ.

Тайлангийн хугацаанд Цахим сургалтын удирдамжийн дагуу ХБМБТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа А.Лхагвадорж “Гэмт хэрэг шалгах ажиллагааны стратеги”, мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Ц.Сайханзориг “Гадаад улсын иргэдийн бичиг баримт, виз, Монгол улсад оршин суух үнэмлэх, ОХУ-ын паспорт, жолооны үнэмлэхний онцлог шинж, нууцлалын талаар зөвлөмж”, эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Д.Мөнхбат “АСАР” сан болон бусад программтай ажиллах ажиллагаа”, “Эрэн сурвалжлах журам”, эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Л.Эрдэмбилэг “Тэсэрч дэлбэрэх бодисын тухай ойлголт”, мэдээлэл судалгааны мэргэжилтэн Б.Өнөр “Цагдаагийн байгууллагын түүхэн хөгжил”, Саатуулах байрны дарга, цагдаагийн хошууч Ө.Баярмаа “Архины хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх”, сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Ц.Тогос “Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг зогсоох тусгай ажиллагаа, “ сэдэвт видео хичээлүүдийг тус тус хариуцан зайны сургалтаар алба хаагчдад орсон байна.

Түүнчлэн алба хаагчдыг хөгжүүлэх, илтгэх ур чадварыг сайжруулах зорилгоор мэдээлэл хийх хуваарь гарган батлуулан офицер бүрэлдэхүүнээс долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагуудад мэдээлэл хийж хэвшлээ.

Газрын үйл ажиллагааны тайлангийн хурлын үеэр алба хаагчдад эерэг хандлага, зөв дадал хэвшил төлөвшүүлэх зорилгоор Эрдэнэзуу хийдийн хамба лам Н.Баасансүрэн, Леди төвийн гүйцэтгэх захирал Р.Лхагвадулам, гэр бүл судлаач, хуульч Г.Нарантуяа нараар лекц уншуулан ажиллалаа.

Тайлангийн хугацаанд ХЗЯ-ны харъяа Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран “Хар тамхи, мансууруулах бодис, түүний хор хөнөөл”, “Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг”, “Гэр бүлийн хүчирхийлэл болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, “Өмчийн эсрэг гэмт хэрэг” сэдвээр багц сургалтыг зохион байгуулж 242 алба хаагч хамрагджээ.

Мөн ЦЕГ-ын Сургалтын төвөөс ирүүлсэн албан бичгийн дагуу 2016 оны Хоёрдугаар улиралд сургалтанд хамрагдах 37 алба хаагчийн, 5 сард сургалтанд хамрагдах 9 алба хаагч, 6 сард сургалтанд хамрагдах 15 алба хаагч, 9 сард сургалтанд хамрагдах 9 алба хаагч, 10 сард сургалтанд хамрагдах 5 албан хаагч, нийт 75 ийн нэрсийг тус тус гарган хүргүүлсэн бөгөөд 70 алба хаагчид хуваарийн дагуу хамрагдсан байна.

Хоёр: Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Цагдаагийн төв байгууллагын даргын болон аймаг, нийслэл, дүүргийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 16 заалт бүхий салбар төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагаас 2016 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга, ёс зүйг дээшлүүлэх, тэдний дунд зохиох сургалт, соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор 68-н заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан биелэлтийг хүргүүлсэн. Төмөр замын харьяа байгууллагуудтай “Түншлэлийн гэрээ”-г байгуулан офицеруудад хариуцуулан өгч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, жилийн эцсээр хариуцсан байгууллагуудад ажлаа тайлагнаж, иргэд, төмөр замчдаас гарсан санал шүүмжлэлд дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан. Улаанбаатар төмөр зам, Зам тээврийн яам, Авто замын хөгжлийн газар, Замын цагдаагийн алба, Үндэсний аюулгүй байдлын газар, Хүний эрхийн комисстой хамтарсан “Төмөр замын гарам, аюултай бүс-2” сэдэвт зөвлөгөөнийг 2016.12.09-ны өдөр зохион байгуулж уг зөвлөгөөнд Төмөр зам дахь цагдаагийн газрын гэмт хэрэг, зөрчлийн танилцуулгыг хийж нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа ачаалал ихтэй гармуудад дээгүүр, доогуур автомашины гарц шинээр байгуулах ажлыг холбогдох байгууллагууд өргөн мэдүүлэхээр болсон бөгөөд төсөв хөрөнгө шийдвэрлэгдэх хүртэл зохицуулагч цагдаа ажиллуулах талаар Улаанбаатар төмөр замын орлогч дарга нараас хүсэлт гаргасныг хүлээн авч төсөв хөрөнгийн тооцоог гаргаж УБТЗ-н даргад хүргүүлж ажилласан.

2016 онд газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг 2016.01.12-ны өдрийн 02 дугаар хурлаар хэлэлцэн 31 заалттайгаар баталлаа. Хэлэлцэх асуудлыг хариуцсан алба хаагчид төлөвлөгөөний дагуу зөвлөлд танилцуулан

ажилласан. Цаг үеийн шинжтэй асуудлыг тухай бүр хэлэлцүүлэн ажиллаа. 2016 оны 12 дугаар сарын байдлаар 26 удаа хуралдан 88 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Гурав: Үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, мэдээллийг тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүн:

ЦБҮАЖ-ын код 110 –ын дагуу Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үр дүнгийн үнэлгээг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн 3 –н чиглэлээр гарган хүргүүлсэн.

Газрын хэмжээнд үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгч ажилласны дүнд гэмт хэргийн илрүүлэлт 75 хувь, учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 95,6 хувьтай байна.

2016 оны “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний санал асуулгыг 4 хэсэг 22 заалт, 197 үнэлгээний үзүүлэлт бүхий 21 хаалттай, 1 нээлттэй асуулгаар ЦЕГ-аас гаргасан квотын дагуу “Нээлттэй хаалга” өдөрлөг, “Мэдээлэл сурталчилгааны галт тэрэг” аяны хүрээнд болон Улаанбаатар төмөр замын байгууллагууд, суудлын галт тэргээр үйлчлүүлсэн 100 иргэнээс жил бүр уламжлал болгон авч “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний 2015 оны тайланг ЦЕГ-ын ДХАБГ-т 27а/2009, 2016 оны тайланг 31а/1676 тоотоор эх материалыг товъёоглон хавтаслан, түүврийн хамт хүргүүлж, 2015, 2014 оны үзүүлэлтүүдтэй харьцуулсан судалгааг хийж, танилцуулгыг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж үүрэг чиглэл авч ажилласан байна.

Дөрөв: Шүүх прокурорын мэдэгдэл, энгийн магадлалын дагуу авсан арга хэмжээ, үр дүн

Цагдаагийн газрын мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагчдын хуулийг хэрэглэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэх албаны сургалтыг 3 удаа явуулснаар байцаан шийтгэх ажиллагаа зөрчиж прокурорын мэдэгдэл шаардлага аваагүй байна.

Тав: Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл:

Гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн талаар:

Урьд оны үлдэгдэл 3, тухайн оны 620 нийт 623 гомдол мэдээлэл шалгасан: Үүнд эрүүгийн албанаас эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 37, харъяаллын дагуу 1

Нийт 608 гомдол мэдээлэл шийдвэрлэснээс

- 302 буюу 49,7 хувийг гэмт хэргийн,

- 15 буюу 2,5 хувийг бусад,
- 1 буюу 0,1 хувийг харъяаллын дагуу шилжүүлж,
- 290 буюу 47,7 хувийг зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна.

Гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:

- 101 буюу 33,4 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- 201 буюу 66,6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан, тэдгээрээс гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлтэй 195, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 6 байна.

Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа:

- 163 буюу 54 хувийг 5 хоногт,
- 139 буюу 46 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:

- 276 буюу 95,2 хувийг шийтгэврээр,
- 5 буюу 1,7 хувийг торгуулийн хуудсаар,
- 2 буюу 0,7 хувийг баривчилж,
- 2 буюу 0,7 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж
- 5 буюу 1,7 хувийг зөрчлийг хянан шалгаж шийдвэрлэх боломжгүй үндэслэлээр шийдвэрлэсэн.

Нийт зөрчлийн талаархи гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа:

- 280 буюу 96,5 хувийг 14 хоногт,
- 10 буюу 3,5 хувийг 15-28 хоногт шийдвэрлэсэн байна.

Бусад шийдвэрлэлт:

-8 гомдол, мэдээллийг газар дээр нь зохицуулсан,

-1 гомдол, мэдээллийг зөвлөлгөө өгсөн,

-6 гомдол мэдээллийг дуудлага худал байсан үндэслэлээр шийдвэрлэсэн байна.

. Бүртгэгдсэн гэмт хэрэг:

- Газрын хэмжээнд эхний 12 сард 86 гэмт хэрэг бүртгэгдсэн.
- Өмнөх оны мөн үеэс 4 буюу 4,4 %-аар буурсан байна.

Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:



Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн төрлөөр:

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гариг:



Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг:



Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:

- Нийт гэмт хэргийн 18 буюу 21 хувийг согтуугаар, хүүхэд оролцсон 2, эмэгтэй хүн оролцсон 21, гэр бүлийн хүчирхийллийн улмаас 1, бүлэглэн гүйцэтгэсэн 20 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Гэмт хэргийн илрүүлэлт:

Гэмт хэргийн илрүүлэлт 77,5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,9 хувиар буурсан.

Илрүүлэлтийг ангиллаар авч үзвэл:



Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг:



Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй түдгэлзүүлсэн 11 хэрэг байгаагаас:

-Бусдын эд хөрөнгийг хулгайлах-5,

-Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх-1,

-Эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэх-5

Гэмт хэрэгт холбогдогчид:

Нийт 83 хүн гэмт хэрэгт холбогдсоны:

-21 эмэгтэй буюу 25 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь урьд оны мөн үеэс 4 нэгжээр буурсан байна,

- Урьд оны мөн үед 18 хүртэл насны хүүхэд холбогдсон хэрэг 10 гарч байсан бол энэ онд 2 буюу нийт холбогдогчдын 2 хувийг эзэлж байна.

Гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:



Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал

Гэмт хэргийн хохирогч, хохирол:

Гэмт хэргийн улмаас:

- 81 иргэн хохирсон, /эмэгтэй-38, хүүхэд-3/
- Нас барсан хүн 25,
- Гэмтсэн хүн 27 байна.

Гэмт хэрэгт хохирогчид насны ангиллаар:



Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол



Тус газрын хохирол нөхөн төлүүлэлт 95,6 % байгаагаас мөрдөн байцаалтын шатанд нийт хохирлынхоо 97.2%, хэрэг бүртгэлтийн шатанд 78,8% тус тус нөхөн төлүүлсэн байна.

Захиргааны зөрчлийн талаар:

Тус цагдаагийн газарт эхний 12 сарын байдлаар нийт 19068 захиргааны зөрчил бүртгэгдсэнийг өнгөөр нь авч үзвэл:

-19063 иргэнийг 306 сая 213,2 мянган төгрөгөөр торгосон.

-Шийтгэврээр 321 хүнийг 13 сая 50,4 мянган төгрөгөөр торгосон байна.

-3 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж,

-2 хүнд баривчлах шийтгэл оногдуулсан.

-Торгуулийн хуудсаар 220 гадаадын иргэнийг 1,100,000 төгрөгөөр торгож, шийтгэврээр 14 гадаадын иргэнд 698,000 төгрөгөөр торгосон.

Шийтгэврээр 321 иргэнийг 13 сая 50 мянган төгрөгөөр торгосноос:

- 92 буюу 28 %-ийг ЗХТХ-аар,
- 188 буюу 58 %-ийг ЗХБАТХ-иар
- 38 буюу 11 %-ийг ТХТХ-аар,
- 3 буюу 0,2 %-ийг АСТТХ-аар тус тус шийтгэл ноогдуулсан байна.

Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийтгэврээр арга хэмжээ авсан байдал:

- Танхайрах 27
- Галт тэрэгний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 39
- ЦАХ-н хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх 20
- Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах 3
- Худалдаа үйлчилгээний журам зөрчих 3

Торгуулийн хуудсаар 18742 зөрчилд арга хэмжээ авсанаас:

- Танхайрах 6186
- Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх 2604
- Бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах 3
- Худалдаа үйлчилгээний журам зөрчих 916
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар 7760
- Бусад 1273

Захиргааны зөрчил үйлдэгдсэн газар, зөрчлийн тоо:



Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн өдөр:

- 2805 нь Даваа гаригт

- 2663 нь Мягмар гаригт
- 2816 нь Лхагва гаригт
- 2964 нь Пүрэв гаригт
- 2515 нь Баасан гаригт
- 2447 нь Бямба гаригт
- 2858 нь Ням гаригт

Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн цаг:
- 06-12 цагт 7075
- 13-18 цагт 6553
- 19-24 цагт 4455
- 01-05 цагт 985

Бүртгэгдсэн захиргааны зөрчил үйлдэгдсдийн онцлог:
- 57 нь согтуугаар
- 3 нь хүүхэд оролцсон
- 46 нь эмэгтэй хүн оролцсон
- 14 нь гадаадын иргэн

Тус цагдаагийн газарт 2016 оны эхний 12 дүгээр сарын байдлаар 2390 хүн саатуулагдсанаас 9 сая 709,850 төгрөгийн үйлчилгээний хөлс авч, 7 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан байна.

Туслах тоо бүртгэлийн талаар:

1. Объектын санд 9 баяжилт,
2. Субъектын санд 151 нийт 160 мэдээлэл оруулсан байна.

Зургаа: Санхүү, нийгмийн асуудлын талаар хэрэгжүүлсэн ажил

2016 оны 12 дүгээр сарын 16 өдрийг хүртэл улсын төсвөөс санхүүжилт 1.195.929,0 төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого буюу цагдаагийн алба хаагч гэрээгээр ажиллуулах гэрээний орлого, бусад орлого 1.290.678,4 төгрөг нийт 2.486.607,4 төгрөгийг төвлөрүүлэн 2.344.472,9 төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Үүнд:

Цалин хөлс нэмэгдэл урамшилд: Үндсэн цалин, нэмэгдэл цалинд 2.076.109,9 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх ЭМД, НДШ-д 25.116.5 төгрөг

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Гэрэл цахилгааны зардалд 8.065.8 төгрөг, халаалтын зардалд 13.281.8 төгрөг, цэвэр бохир усны зардалд 6.411.3 төгрөг.

Хангамж бараа материалын зардал: Бичиг хэргийн зардалд 1.293.9 төгрөг, шуудан холбооны зардалд 3.112.0 төгрөг, Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 2.368,2 төгрөг.

Норматив зардал: Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 732,9 төгрөг, Хоол, хүнсэнд 13.79,4 төгрөг, Нормын хувцас, зөөлөн эдлэлд 300,0 төгрөг Хөдөлмөр хамгаллын зардалд 630,2 төгрөг.

Дотоод албан томилолтын зардалд 2.416,5 төгрөг.

Бараа, үйлчилгээний бусад зардал: Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 175,5 төгрөг

Харуул хамгаалалтын зардал: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд 144.687,0 төгрөг тус тус зарцуулсан.

Цагаан сараар ахмадыг хүлээн авахад давхардсан тоогоор 84 ахмадыг хүлээн авахад 661,5 төгрөг, Цагдаагийн байгууллагын 95 жил, ахмадын хорооны 50 жилийн ойг тохиолдуулан цагдаагийн хэлтсийн 80 ба түүнээс дээш ахмад настанд 3 хонины мөнгө 420,0 төгрөг, Ахмадын эрхийг хамгаалах өдөр ахмадыг хүлээн авахад 364,6 төгрөг, нийт 1.446,1 төгрөг зарцуулсан. Ахмад настан, хэлтсийн ажилтан 6 хүнд 1.140,0 төгрөгөөр өвлийн түлш /нүүрс/-ний тусламж үзүүлсэн.

Санхүүгийн 2014 2015, 2016 оны IY улирлын харьцуулалт:

Орлого:

Үзүүлэлт	*2014 он*	*2015 он*	*2016 он*
Төсвийн санхүүжилт	726742700,00	1004275100,00	1195166300,00
Системийн дотоод тооцоо	66858642,00	15187028,00	13147757,50
Үндсэн үйл ажиллагааны орлого	2333178,00	67958,00	1290678400,00

Орлого/графикаар/



Зардал:

Үзүүлэлт	*2014 он 4-р улирал*	*2015 он 4-р улирал*	*2016 он 4-р улирал*
Цалин хөлс, нэмэгдэл, НДШ, ЭМД /Үр дүнгийн тайлан/	1366446635,00	1675717407,00	199570999,00
Урсгал зардал:	129846911,37	234093274,38	2342902994.85
Бусад зардал	29419200,00	930100,00	0.00

Зардал/графикаар/



Хөрөнгө:

Үзүүлэлт	*2014 оны 4-р улирал*	*2015 оны 4-р улирал*	*2016 оны 4-р улирал*
Бараа материал	137540681,56	134174313,75	138157253.92
Үндсэн хөрөнгө	185545168,75	165079128,16	159215478.87
Нийт хөрөнгө - /өглөг авлагаас бусад/	380700408,31	497912576,85	345985426.66

Хөрөнгө /графикаар/



Гэрээт харуул хамгаалалтын зардал:

2016 оны 1-дүгээр сарын 01-ны өдөр УБТЗ нийгэмлэгтэй байгуулсан гэрээний төсвөөр 95 офицер, цагдаа ажиллуулахаар 1.229.018,2 төгрөгийн гэрээг хийсэн. 2016 оны 12 сарын 16-ны байдлаар 1.229.018,2 төгрөгийн санхүүжилт авахаас 1.279.474,7 төгрөгийн санхүүжилт авсан.

Торгууль, шийтгэвэр:

2016 оны жилийн эхэнд 5000 төгрөгний 88 төгрөгний үнэтэй 563 ширхэг торгуулийн хуудас, 110 төгрөгний үнэтэй 94 ш шийтгэвэрийн үлдэгдэлтэй байсанаас 1-12 сард Торгуулийн тасалбар 11,000 ширхэг, шийтгэвэр 300 ширхэгийг орлого авч, 10058 ширхэг торгуулийн хуудсаар 50.290,0 төгрөгийн орлого 187 ширхэг шийтгэвэр зарлага болгож 6.013,1 төгрөгийн нийт 56.303,6 төгрөгийн орлогыг ЦЕГ-ын торгууль шийтгэврийн дансанд төвлөрүүлж ажиллаа.

Цаашид хийх ажил:

2017 онд Төсөв, санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор урсгал зардлаас тэвчиж болох зардлыг хассагнтай холбоотой, хэмнэлтийн горимд шилжиж ажиллана.

Монгол улсын засгийн газрын 2014 оны 86 дугаар тогтоолын дагуу Цагдаагийн алба хаагчид мөнгөн урамшил олгох журмын дагуу 2017 оны Гэрээт алба хаагчдыг ажиллуулах гэрээнд Мөнгөн урамшууллын зардал , гэрээт алба хаагчдын нормын дүрэмт хувцасны зардлыг 2014 оноос хойш төсөвт зардлаас хасч санхүүжүүлж байгааг нэмж оруулах саналыг УБТЗ-ын удирдлага, санхүүтэй уулзаж шийдвэрлүүлэхийг цаашид хийх ажлын саналд оруулж байна.

Долоо: Бусад ажлын талаар:

Төмөр зам дахь цагдаагийн газрын эрүүгийн, эдийн засгийн болон хэсгийн төлөөлөгч нар 2016 онд 118 холбогдогчтой 1 тэрбум 428 сая 690 мянган төгрөгний хохиролтой 105 гэмт хэрэг илрүүлэн ажилласан байна. 2016 онд Гүйцэтгэх ажлын мэдээ мэдээлэл урьд оны мөн үеийнхээс 71 буюу 16,1 хувиар өссөн байна. Мөн 2015 онд нийт 80 гэмт хэрэг, үйлдэл илрүүлэн харьяалах албанд шилжүүлж байсан бол 2016 онд 105 гэмт хэрэг үйлдэл илрүүлж урьд оны мөн үетэй харьцуулахад 25 буюу 19,1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Бусад албанаас гэмт хэргийн шинжтэй 51 илтгэх хуудас хүлээн авч шалгаж ажилласан байна.

Тус цагдаагийн хэлтсээс 2016 оны байдлаар цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах ажлын “ASAP” санд оргодол 2, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 1, эд зүйлс 4, , нийт 7 эрэн сурвалжлах хүн, цогцос, эд зүйлсийн мэдээлэл бүртгэгдэж зарлагдсан ба үүнээс оргодол 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 1, эд зүйл 2, нийт 16 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоосон байна. Үүнд:

1. Тус хэлтсээс эрүүгийн 201624000163 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000011 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 25 настай Гомбожав овогтой Энхбат РД:/УП91031509/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,
2. Тус хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000004 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Гончиг овогтой Даваасүрэн РД:/ Н362022675 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,
3. Тус хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000002 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 23 настай Төмөрбаатар овогтой Хулан РД:/ЕЙ92080802/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,
4. Тус хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000011 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 29 настай Хүрэлбаатар овогтой Майцэцэг РД:/ЕА86050108/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,
5. Тус хэлтсээс гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000025 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 23 настай Батбаяр овогтой Батсүрэн РД:/СЧ92082236/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,
6. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000005 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Рэнцэнханд овогтой Рэгзэдмаа РД:/ УО63072951 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

7. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000012 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 53 настай Бямбадорж овогтой Буянхишиг РД:/ ЕЙ95112908 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

8. Тус хэлтсээс оргодлоор “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000010 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 23 настай Батбаяр овогтой Батсүрэн РД:/СЧ92082236/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

9. Тус хэлтсээс эрүүгийн 201524000266 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000011 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 39 настай Сүхээ овогтой Батхүү РД:/ТД:77051377/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

10. Тус хэлтсээс эрүүгийн 201524001017 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001315000023 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 42 настай Доржгочоо овогтой Мандах РД:/УД:74020774/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

11. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000017 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

12. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000010 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

13. Тус хэлтсээс эрүүгийн 201624000319 тоот дугаартай хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000015 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 24 настай Баасан овогтой Мөнх-Эрдэнэ РД:/ВЮ92102534/-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

14. Тус хэлтсээс эрүүгийн 201524001211 тоот хэрэгт гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000028 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 33 настай Мөнхцас овогтой Анар РД:/ АЮ83120364 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

15. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000015 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

16. Тус хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540001316000014 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан эд зүйлийг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар хэлтсээс Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах “ASAP сан”-д бүртгэгдэж зарласан гэрээсээ гараад сураггүй алга болсон 7 олж тогтоон нутаг дэвсгэрийн цагдаагийн хэлтсүүдэд хүлээлгэн өгч ажилласан байна.Үүнд:

1. БЗД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540005313000350 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 20 настай Цогтгэрэл овогтой Батсолонго РД:/ СЮ93032506 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

2. ЧД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс Эрүүгийн 201441052353 тоот хэрэгт “Эрэн сурвалжлах АСАП” санд 540006114000078 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 61 настай Надмид овогтой Зина РД:/ УС:55061502 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг

3. ХУД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд маягтын 541106016000045 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 39 настай Шархүү овогтой Энхтүвшин РД:/ ШЖ:77111300 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг

4. СХД-ийн цагдаагийн 3-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540006316000361 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 27 настай Батбуян овогтой Уранчимэг РД:/ ТК88081401 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг

5. БЗД-ийн цагдаагийн 3-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540007316000017 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 28 настай Дагвадорж овогтой Болормаа РД:/ УК88080805 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг,

6. ЧД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 541106116000147 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 30 настай Цэндбаатар овогтой Мөнхсүх РД:/ уе86082105 /-ыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг

7. ХУД-ийн цагдаагийн 2-р хэлтсээс “Эрэн сурвалжлах АСАП” санд 540006016000420 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан 38 настай Батбуян овогтой Уранчимэг РД:/ТК88081401 /-ыг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг тус тус зогсоож ажилласан байна.

Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн сэтгэл зүйчийн зүгээс:

- 2015 оны Үр дүнгийн гэрээний илтгэх хуудсыг бичин танилцуулж 91 буюу “А” үнэлгээтэй дүгнэгдэн 2016 оны Үр дүнгийн гэрээг байгуулав.
- “ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдүүллээ.
- “Тэнгэрлэг гэр бүл” ар гэрийн уулзалт арга хэмжээг зохион байгуулан 126 алба хаагчийн гэр бүлд урилга хүргүүлэн, 48 алба хаагчийн ар гэр хамрагдан удирдлага, цагдаагийн алба хаагчийн эргэх холбоог тогтоох, тэдний санал хүсэлтийг сонсох, цаашид алба хаагчийн нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон арга хэмжээ болсон болно.
- “Бие хүний онцлогийг харгалзан харилцах нь”, “Харилцаанд сөргөөр нөлөөлөх 23 биеийн хөдөлгөөн, өөртөө итгэлтэй байх 8 арга”, “Утсаар харилцах харилцааны сэтгэл зүйн онцлог”, “Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед ажиллах сэтгэл зүйн бэлтгэл” сэдвүүдээр тус тус сургалт орж,
- Хэрэг бүртгэх эрхтэй алба хаагчдад “Полиграфийн даалгавар бичих арга зүй, анхаарах асуудал” сэдвээр МБГ-ын ахлах сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Оюунбилэгээр, “Цэргийн нөхөрлөл” ОУБ-ын сургагч багш, доктор, профессор Виктор Салазараар “Харилцах ур чадвар, сэтгэл зүйн бэлтгэл”, Эрдэнэзуу хийдийн хамба лам Н.Баасансүрэнгээр “Хайрлахуй ба зав хандлагатай байх нь”, алба хаагчдад эерэг хандлага зөв дадал хэвшил төлөвшүүлэх, хувь хүн, байгууллагын соёлыг дээшлүүлэх зорилгоор “Төрийн албаны шинэчлэлийн үе дэх харилцаа, хувцаслалт, хувийн соёл” сэдвээр Леди төвийн захирал Р.Лхагвадулам, “Эерэг хандлага, эрүүл дадал зуршлыг төлөвшүүлэх нь” сэдвээр СЭМҮТ-ийн их эмч Ж.Гантулга, “Аз жаргалыг өөртөө бий болгох, аз жаргалтай гэр бүл орших нь “ сэдвээр гэр бүл судлаач Б.Нарантуяа, “ХЗЯ-ны харъяа Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран “Архины хор уршиг хөнөөл”, “Гэр бүлийн хүчирхийлэл ба Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, “Хар тамхи мансууруулах бодис, түүний хор хөнөөл”, “Өмчийн эсрэг гэмт хэрэг” сэдвүүдээр багц сургалтуудыг зохион байгуулав.
- Сэтгэл зүйчийн ажлын өрөө, алжаал тайлах танхимын интерьер зураг, төсвийг шинэчлэн гаргаж танилцуулав.

- ЦЕГ-ын сургалтын төвөөс зохион байгуулсан Сэтгэл зүйчдийн 6 хоногийн нэгдсэн сургалтанд болон Хууль сахиулах байгууллагуудын сэтгэл зүйчдийн 2 хоногийн нэгдсэн сургалтанд тус тус хамрагдав.
- Цагдаагийн алба хаагчийн ажил үйлчилгээний стандарт, тавигдах шаардлага, анхаарах асуудал, хүлээлгэх хариуцлага" сэдвээр гарын авлага боловсруулан хэрэглээнд оруулав.
- ЦЕГ-ын б/217 тоот тушаалын дагуу "Нарстай" дахь хээрийн дадлага сургалтын хүрээнд "Харилцааны ёс зүй, сэтгэл зүйн бэлтгэл" багт сургагч багшаар 2016.05.01-06.20-ны хооронд үүрэг гүйцэтгэж ажиллав.
- Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу "Зөв харилцаанд суралцах нь" сэдвээр 4 цагийн сургалт зохион байгуулж, хүсэлт гаргасан алба хаагчидтай ганцаарчилсан зөвлөгөө өгч ажиллаа.
- ЭЦГ-ын гаргасан хүсэлтийн дагуу "Харилцааны сэтгэл зүй ба, өөртөө итгэлтэй байж аз жаргалыг дуудах нь" сэдвээр сургалт оров.
- Хөдөлмөр хамгааллын сандлаар 335 алба хаагчид 6700 минут буюу 112 цагийн үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Эрүүгийн цагдаагийн тасгийн
Жижүүрийн шуурхай удирдлагын хэсгээс:

ЦБҮАЖ-ны код 200.4.4. 202-т заасны дагуу албан байгууллага, иргэдээс 434 мэдээ мэдээлэл, дуудлага хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 155, захиргааны зөрчлийн шинжтэй 267, дуудлага буцаагдсан 4, газар дээр нь зохицуулсан 8 мэдээлэл хүлээн авсан. ЦБҮАЖ-ын код 201.5.6 заасны дагуу төвөөс сүлжээгээр гэмт хэргийн-3557, хүн болон эд зүйл эрэн сурвалжилсан-3158 зарлан мэдээлэл хүлээн авч, эргүүл постонд дамжуулан эрэн сурвалжлах ажиллагаа зохион байгуулж ажилласан.

Бүгд найрамдах Унгар улсын Ерөнхий сайд Виктор Орбал зочид төлөөлөгчдийн хамт, БНЭнэтхэг улсын доод танхимын дарга, эрхэмсэг хатагтай Суматри Махажан, БНИтали улсын Парламентын сенатын танхимын дарга, Пьетро Грассо нар Монгол улсад айичилсан зэрэг 1-р зэрэглэлийн хамгаалалт, Шинэ оны нар харах үйл ажиллагааны хамгаалалт, Монгол улсын Ерөнхий сайд Улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудалд ирэх үеийн болон гадаадын зочид төлөөлөгчид ирэх явах үеийн хамгаалалт, ОХУ-ын элчин сайд, замын дарга нар ЗҮТБ-ын хөшөөнд цэцэг өргөж ОХУ-ын иргэдэд хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагааны зэрэг эргүүл болон хамгаалалтанд гэмт хэрэг, зөрчил гаргуулалгүй ажилласан.

Ази-Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт Монгол улсад зохион байгуулагдах үеийн хамгаалалтанд 07 дугаар сарын 13-ны өдрөөс 18-ны өдрийг дуустал Хан-Уул дүүргийн нутаг давсгэр, 120 мянгатын уулзвараас Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн замын уулзвар хүртэл, Энхтайваны гүүрэн доор, замын цагдаагийн пост гармуудад нийт давхардсан тоогоор 358-н алба хаагч хамгаалалтын зөрчил дутагдалгүй ажиллаж хамгаалалт эхлэхийн өмнө гэмт хэрэг, зөрчил, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг явуулж сапиорчдод хүлээлгэн өгсөн.

Үндэсний их баяр наадам, ардын хувьсгалын ойн баярын хамгаалалт, Даншиг наадам, Төмөр замчдын мэргэжлийн өдөрлөг, 67-н жилийн ойн баярын хамгаалалт, ТРАНС СИБИРЬ төмөр замын тээвэрлэлтийн зохицуулах зөвлөлийн 25-р их хуралд 26 орны зочид төлөөлөгч ЗҮТБ, Хонхор өртөөнд аялах үеийн, Монгол улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Сэлэнгэ, Дарханд ажлын айлчлал хийх үед хамгаалалтын зөрчилгүй ажилласан.

Улсын их хурлын сонгууль, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үед тус цагдаагийн газрын нийт алба хаагчдад нийтийн хэв журам хамгаалах албанаас ирүүлсэн зөвлөмжийг хүргүүлж сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтуудаар ахлах хэрэг бүртгэгч сургалт зохион байгуулж алба хаагчид нэмэгдлээр сонгуулийн хэсгийн хорооны гадна талбай орчимд хөдөлгөөн зохицуулж ажилласан нөхцөл байдлын талаарх мэдээг ЦЕГ-ын ШУШтабд болон шонхортой тухай бүр холбогдож өгсөн. Алба хаагчдаас ямар нэг зөрчил дутагдалгүй хэвийн ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар:

Цагдаагийн байгууллагаас 2016 онд хэрэгжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тасаг албадаас төлөвлөгөөнд тусгуулах саналыг авч нэгтгэн Монгол-оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг улаанбаатар төмөр замын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга, төмөр зам дахь цагдаагийн газрын дарга нарын баталсан 7 бүлэг 45 зүйлтэй төлөвлөгөө боловсруулан биелэлтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал,Засгийн газраас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой “МУ-ын Ерөнхийлөгчийн 97-р зарлиг “Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах тухай”, Засгийн газрын 2006 оны 282 дугаар тогтоолоор баталсан “Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2011 оны 257 дугаар тогтоолоор баталсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөр”, Засгийн газрын 2012 оны 252 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”, Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 67 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” болон ЦЕГ-ын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, Нийтийн хэв журам хмагаадал албаны дарга, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга нараас өгсөн үүрэг,албан даалгавар,тушаал, шийдвэрүүдийгхэрэгжүүлэхажлыгзохионбайгуулж үүрэг даалгаварын биелэлтийг тасгийн ахлах байцаагч нартай хамтран цаг хугацаанд нь явуулсан.

2016 онд Гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөл, төмөр зам дагуух Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт, Зүүнхараа, Замын-Үүд, Сайншанд, Чойр өртөөдөд гэмт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн шинээр байгуулан, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаа. Үүнд: Тус газрын дарга, цагдаагийн хурандаа М.Отгонбаяр, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа А.Лхавгадорж, Эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад Э.Одбаяр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад Д.Өнөртөгс, жолооч цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Б.Амгаланбаяр нар нь 2016 оны 06 дугаар сарын

12-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ныг өдрийг дуустал Эрдэнэт, Дархан, Сүхбаатар,Баруун хараа, Зүүнхараа, Салхит, Түнх зэрэг 7 өртөө, зангилаадад албан томилолтоор ажиллаж өртөө, зангилаадын дарга нартай уулзаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл хэрхэн ажиллаж байгаа талаар ажлыг шалган зааварчилж ажилласан. Мөн Орхон, Эрдэнэт, Сэлэнгэ аймгийн Мандал сумын цагдаагийн газар, газрын дарга нартай уулзаж цагдаагийн ерөнхий газар, улаанбаатар төмөр замын хамтын ажиллагааны " Санамж бичиг"ийн хэрэгжилт, хэрхэн уялдаа холбоотой ажиллах талаар санал бодол солилцож ажилласан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааг сайжруулж уялдаа холбоотой ажиллах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтруулан 4 томоохон зөвлөгөөн зохион байгуулж ажиллаа. Үүнд: Улаанбаатар хотын дүүргүүд болон орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдтэй уялдаа холбоогоо сайжруулж хамтран ажиллах зорилгоор нийслэлийн Баянгол дүүрэг дэх цагдаагийн 1,2 дугаар хэлтэс, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Баянзүрх дүүргийн цагдаагийн 1,3, дугаар газрын нийтийн хэв журам хамгаалалх тасгийн дарга, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах байцаагч, тухайн нутаг дэвсгэрийн төмөр зам дайран өнгөрдөг хороо хариуцсан хэсгийн байцаагч, улаанбаатар төмөр замын улаанбаатар хот дахь байгууллагуудын төлөөлөл гэх нийт 70 орчим ажилтан алба хаагчдыг оролцуулан " Төмөр замын аюултай бүсийн дэглэмийг сахиулах, эрсдлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа сэдэвт сургалтыг 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 10:00-12:00 цаг хүртэл төмөр замын удирдах газрын "Б" зааланд зохион байгуулан ажилласан.

2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Төмөр зам дахь цагдаагийн газар, Тээврийн прокурорын газраас хамтран хилийн боомт дээр ажиллаж байгаа хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, Монгол улсын эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлд заасан "Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хойшлуулашгүй ажиллагааг чанартай явуулж ул мөр бэхжүүлэх нотлох баримтыг хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулах, хураан авах, энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээл сэдвээр харилцан саналсолилцож, Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх" сэдэвт" зөвлөгөөнийг зохион байгуулсан.
2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр "Төмөр замын гарам -аюултай бүс", төмөр замын гарам аюултай бүс -2, зөвлөгөөн 3 удаа зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд Улаанбаатар хот дотор үйлчилгээ эрхэлж буй Нийслэлийн тээвэр зохицуулалтын газар, Нийслэлийн зорчигч тээврийн нэгдэл, "Тэнүүн огноо" ХХК, "Эрдэм транс" ХХК, "Сутайн буянт" ХХК, "Атибус" ХХК, "Эмсид" ХХК зэрэг 20 гаруй аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтан албан хаагч нар хамрагдсан.

2016 оны 12 дугаар сарын 09-ны өдөр улаанбаатар төмөр замтай хамтран " Төмөр замын аюултай бүс-2" зөвлөгөөн зохион байгуулсан. Зөвлөгөөнд Зам тээврийн яам, Хүний эрхийн комисс, Улаанбаатар хотын замын цагдаагийн газар, хэлтсүүдийн удирдлагууд гэх мэт 20 гаруй байгууллагын удирдах ажилтан, төлөөлөл хамрагдсан.

2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дуусталх хугацаандтус газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад Д.Өнөртөгс, Замын хөдөлгөөний ахлах зохицуулагч, цагдаагийн

хошууч М.Мягмарсүрэн, Саатуулах байрны дарга, цагдаагийн хошууч Ө.Баярмаа нар нь төмөр зам дагуух Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт, Зүүнхараа, Замын-үүд, Сайншанд, Чойр зэрэг 7 өртөө зангилаадад ажиллаж, оршин сууж буй төмөр замчид болон орон нутгийн мал бүхий иргэд, орон нутгийн цагдаагийн газар , нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн газрын алба хаагч нарт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цогц мэдээлэл өгөх зорилгоор “Мэдээлэл сурталчилгааны галт тэрэг” аяныг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны төв, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Улаанбаатар төмөр зам, Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагуудтай хамтран 10 хоногийн хугацаанд нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан ажилласан.

Хэв журмын оифцер, цагдаагийн ахлах дэслэгч Т.Энхтүвшиний хамт Сонгиохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрлах 361 гармын орчимд ажиллаж амьдардаг мал бүхий 22 иргэдтэй уулзаж төмөр замын аюултай бүсийн дэглэм болон тэр төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж 3 төрлийн 66 ширхэг гарын авлага материалыг тараан ажилласан. Гал унтраах ангийн 50 гал сөнөөгчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн их эмч Ж.Гантулгаар архины хор хөнөөл, ажлын байрны стрессын талаар, Аялал жуулчлалын товчооны харъяа 9 энгийн харуул, манаач нарт эргүүл, харуулын дүрэмээр, улаанбаатар татах хэсгийн 65 ажилтанд зэрэг 3 байгууллагын 146 иргэнд яриа хийсэн. Цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, малчин иргэдийн хамтын ажиллагааг дээшлүүлэх тэдэнд төмөр замын аюултай бүсийн дэглэм болон учрах эрсдлийг ойлгуулах чиглэлээр дэс дараалсан арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус цагдаагийн газрын алба хаагчид болон бсуад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран “ Сар шинэ”, “Нүүрс”, “ Шалгалт”, “Төмөр замын аюултай бүс гарам”, Замын хөдөлгөөний цагаан толгой-2016”, “ Хөдөлгөөнт эргүүл”,”Аюултай бүс”,”Төмөр замын аюултай бүсийн дэглэм”-ийг сахиулах, эрсдлийг бууруулах чиглэлээр хамтын ажиллагаа зөвлөгөөн,”Төмөр замын гарам аюултай бүс-1, Төмөр замын гарам аюултай бүс-2, Хяналт”, “Замын хөдөлгөөний соёл-бидний оролцоо”, “Тэнэмэл”, Хяналт шалгалт-1”,” Төмөр замын гарам”, ”Хяналт шалгалт-9”, “ Зөрчлийн илрүүлэлт”,”Шалгалт”, “Хурд бүс”,”Хориотой бүс”, “Тор”, ”Гарам”, “Оюутан тээвэр”, “ Хурд бүс” мэдээлэл сурталчилгааны галт тэрэг аян, нээлттэй хаалганы өдөр 1,2,3,4,5,6,7, хяналт шалгалт, “ Шинэ жил” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 30 удаа зохион байгуулсан.

Монгол улсын гэмт хэргээс урьдчилан сэргйилэх тухай хууль, Улаанбаатар төмөр замын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлын хүрээнд Замын даргын 99 тоот албан даалгаврын дагуу Улаанбаатар хот дахь 32байгууллагыг оролцуулан “Олон нийтийн эргүүл”-ийн хуваарь хийж, Амгалан, Толгойт, төвийн гэсэн 3 чиглэлд 35 удаа 35 офицер, 42 замчин ажиллаж төмөр замын харъяа байгууллагын харуул манааны сонор, сэрэмж, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавин ажилласан. Олон нийтийн рэгүүл шалгалтаар нэг удаа явахад 10,000 төгрөгний бензин шатахууныг гэмт хэрэг урьдчилан сэргийлэх зөвлөлөөс тухайн байгууллагын дансанд шилжүүлэн ажилладаг болно.

2015 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал улаанбаатар хот дахь 32 байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулж, 32 офицерт хуваарилан гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажилласан.

Төлөвлөгөөнд заагдсаны дагуу 2015 онд гэмт хэрэг, зөрчилгүй байгууллагаар шалгарсан Улаанбаатар өртөө, Толгойт өртөө, Авто вокзал, Ган зам пресс, Ус хангамж эрчим хүчний 1 дүгээр анги, Дохиолол холбооны 2 дугаар анги, Төв засврын газар зэрэг 7 байгууллагад "Батламж", галт тэрэгний дүрс бүхий бармилаар хийгдсэн дурсгалын зүйлээр, олон нийтийн эргүүлд идэвхи санаачлагатай бусдыгаа хошуучлан ажилласан Хангамжийн албаны жолооч Д.Банди, хэв журмын офицер, цагдаагийн ахлах дэслэгч Т.Энхтүвшин, Улаанбаатар татах хэсгийн хүний нөөцийн албаны менежр Ө.Энхбаатар, хэв журмын офицер, цагдаагийн ахмад Ц.Энхтайван, Дохиолол холбооны 2 дугаар ангийн жолооч С.Бадамраа, ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч Б.Намнандорж нарыг тус бүр 90,000/ ерэн мянган төгрөгөөр шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан.

УБТЗ-ын 32 нэгж байгууллагын дарга нартай 2015оны 01-р сарын25-аас 2016 оны 01 дүгээр сарын 10-ныг дуустал төмөр замын салбарт үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах, аж ахуй нэгж дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж буй ажлыг эрчимжүүлэх, төмөр замчдад шинээр батлагдан гарсан хууль эрх зүйн мэдлэгийг сурталчлах, мэдлэгийг дээшлүүлэх, иргэд, төмөр замчдын оролцоог сайжруулах чиглэлээр 6 бүлэг 33 заалт бүхий "Түншлэлийн гэрээ"-г хэрэгжүүлэн ажиллахаар байгууллага, аж ахуйн нэгжийг 32 офицерт хуваарилан өгч, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 128-ын дагуу тайлангаа тавьж хамтран ажилласан. 2016 онд ажиллах Олон нийтийн эргүүлийн хуваарийг хийж Улаанбаатар төмөр замын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга Л.Халтар, Төмөр зам дахь цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа М.Отгонбаяр нараар батлуулан, Хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдалгаар ханган ажиллаж байна.

2016 онд Олон нийтийн эргүүлийг 36 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 150 аж ахуйн нэгж байгууллагыг шалгаж, эргүүл шалгалтаар заагдсан зөрчил дутагдлыг газар дээр нь болон хугацаатай албан мэдэгдэл бичиж хариуг хугацаанд нь авч ажиллаа.

Гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгах зорилгоор төмөр замын харъяа аж ахуйн нэгж байгууллагуудад 125 удаа албан мэдэгдэл бичиж 100 албан мэдэгдлийн хариуг хугацаанд авч, албан мэдэгдлийн мөрөөр 20 аж ахуйн нэгж байгууллагад шалгалт хийж дутагдлийг засуулан ажилласан.

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааныхөтөлбөр"-хүрээнд Монголын үндэснйи олон нийтийн радио, телевиз, TY5, TY9, UBS, монгол HD болон Сэлэнгэ аймгийн миний монгол, Дархан уул, Эрдэнэт, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Дорноговь аймгийн Сайншанд сум, Говь сүмбэр зэрэг аймаг орон нутгийн телевиз болон улаанбаатар зорчигч үйлчилгээний төв буудлын ард, авто зогсоол руу харсан сурталчилгааны дэлгэц, зорчигч үйлчилгээний төв буудал дотор байрлах хүлээлгийн танхим, өртөө зангилаадад байрлах хүлээлгийн танихмын дэлгэцээр Хүн худалдах, Төмөр замын Аюулгүй бүс, Архины хор холбогдол, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төмөр зам аюултай бүс зэрэг 8 төрлийн санамж, сэрэмжлүүлэгийг бэлтгэн иргэдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна. 2016 онд давхардсан тоогоор сонин хэвлэлд 15,

телевизэд 50 удаа сэрэмжлүүлэг, яриа таниулга хийж 35 төрлийн 5100 санамж сэрэмжлүүлгийг траан ажиллаа.

10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээ, мэдээлэл өгч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр өгөөжийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх ажилд хамтран ажиллаж байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын нийт бие бүрэлдэхүүн болон төмөр замын харъяа байгууллагуудын алба хаагч ажилтнуудад Хууль зүйн яамнаас бэлтгэн гаргасан 24 ангид цуврал киног үзүүлсэн, авлигын эсрэг хуулийг хэрэгжилтийг хангахаар Авлигатай тэмцэх газрын сургалт, соён гэгээрүүлэр, урьдчилан сэргйилэх газрын ажилтан комиссар Дэлгэрбаярыг урьж сургалт оруулж алба хаагчдаас баталгаа авсан.

Улсын баяр наадам болж байгаатай холбоотой Улаанбаатар төмөр замын замын 2 дугаар ангийн инженер Одбаяр, тор засагч Лхавгаа нартай хамтран хүй долоо худгийн орчимд зунждаг 15 мал бүхий айл өрхөөр орж төмөр замын аюултай бүсийн дэглэмээр сургалт сурталчилгааг хийж, 3 төрлийн 45 ширхэг санамж, материал тараан, 15 ширхэг мэдэгдэх хуудсыг тараан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан.Оюутан цагдаа хөтөлбөрийн хүрээнд тус газарт томилогдон ажилласан Тунгалаг-Од, Х.Мянганцэцэг, Б.Хонгорзул, А.Дөлгөөн нарт зааварчилга өгч, мэргэжлийн удирдлагаар ханган тухай бүр хийсэн ажлын дүн мэдээг нэгтгэн холбогдох газарт хүргүүлж ажилласан.

Хуулийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн болж байгаатай холбогдуулан удирдлагаас өгсөн үүргийн дагуу тус газрын үйл ажиллагааг сурталчлахаар 160х60 хэмжээтэй слайдан самбарын бэлтгэн хэвлүүлсэн.

Галын аюулд өртөж эд хөрөнгөөрөө хохирсон тус газрын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Б.Ангара, Пүрэвжаргал нарын талаар Монгол-оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг улаанбаатар төмөр замын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга Л.Халтарт уламжлан тус бүр 100,000 ширхэг паалк модыг хөнгөлттэй үнээр авч өгсөн. Мөн Жи Эй Си олон улсын байгууллагад хандан цагдаагийн ахлах ахлагч Б.Ангарад 5 ханатай шалтай, гэр, цагдаагийн ахлагч Пүрэвжаргалд 500,000 төгрөгний мөнгөн тусламж олгуулж , тасгийн хамт олноороо хэлэлцэж өрх толгойлсон болон өрхийн орлогыг нь харгалзан үзэж 20-н алба хаагчид хүнсний болон эд материалын 1 удаагийн тусламж олгосон.

Албадан саатуулах байрны ажил, архидан согтуурахаас сэргийлэх ажлын хүрээнд:

Саатуулах байр нь 2016 онд архидан согтуурч, захиргааны зөрчилд холбогдсон 2430 эмэгтэйг хүлээн авч саатуулсанаас 2365 хүнээс 9871700 төгрөгний төлбөр гаргуулан санхүүгийн албанд тушааж төлбөр төлөлт 97,3%-тай гарсан.

Нийт албадан саатуулагдсан иргэдийн албадан хүргэгдэж ирсэн шалтгааныг тодруулбал:

1.Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан –1683

2. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон –562

3.Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож, гэмт хэрэг зөрчилд холбогдсон – 185

Саатуулах байранд бусад дүүрэг цагдаагийн хэлтсээс хүргэгдэн ирсэн иргэдийн биед эмч нар эмнэлгийн үзлэгийг чанартай хийж, саатуулах байранд 340 иргэнийг ЭЯТТ 103-т дуудлага өгч , эрүүл мэндийн байдал нь шаардлага хангахгүй дараагийн шатлалын эмнэлгийн тусламж авах шаардлагатай 23 иргэнийг хүлээлгэн өгч, 6 иргэнийг ар гэр асран хамгаалагчид, 14 иргэнийг эмчийн үзлэгт оруулан саатуулах байранд саатуулсан байна.

Саатуулагдсан 2430 иргэдийн талаархи мэдээлэлийг ЦЕГ-ын Захиргааны тоо бүртгэлийн санд оруулж, газрын мэдээлэл судалгааны ахлах байцаагч цагдаагийн ахмад Ц.Сайханзоригтой 2430 эмэгтэйчүүдийн мэдээлэлийг тулгаж, дугаар давхардсан, мэдээлэл дутуу шивэгдсэн эсэхэд хяналт тавин ажилласан. Үүрэг гүйцэтгэж байгаа 8 цагдаагийн алба хаагчид саатуулах байранд саатуулагдах хугацаандаа ЦАХ-ийн хууль ёсны шаардлага биелүүлээгүй 188 иргэнийг ЗХТХ-ийн 30.2.1 зүйлээр 940,000 төгрөгөөр торгож, төлбөрийг тухай бүрт нь төрийн санд тушааж санхүүд тооцоо нийлж мэдээллийн санд шивж оруулсан байна.

Саатуулах байрны эмч,цагдаа нар Цагдаагийн байгууллагын холбогдох код, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон сонор сэрэмжтэй, иргэдэд шуурхай үйлчилгээг үзүүлж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллан, камерын хяналтыг биечлэн тавьснаар саатуулагдсан иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндийн өөрчлөлт, эд зүйлээ алдах, амь нас эрсдэх тохиолдол гараагүй болно.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр:

2016 онд ЦЕГ-ын Төмөр зам дахь цагдаагийн хэлтсээс УБТЗ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хийсэн төлөвлөгөөний дагуу газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Ахлах байцаагч, цагдаагийн ахмад Д.Өнөртөгс, Замын цагдаагийн Ахлах байцаагч цагдаагийн хошууч М.Мягмарсүрэн, АСТАБ,цагдаагийн хошууч Ө.Баярмаа нар “Мэдээлэл суртчилгааны галт тэрэг-2016 он” аяны хүрээнд Монгол улсын “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгаа үйл ажиллагаа нь хуулийн дагуу явагдаж байгаа эсэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй ажлыг шалгахаар “Хяналт шалгалт-9” хэсэгчилсэн арга хэмжээ зохион 2016.10.30-2016.11.10 өдрүүдэд Замын үүд,Сайншанд,Чойр, Зүүн хараа,Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ өртөө зангилаад дахь шугам замын архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг Ган зам хүнсний дэлгүүр, Жинчин рестораны үйл ажиллагаанд хяналт тавьж батлагдсан цагийн хуваарийн дагуу ажиллах үүрэг өгч сэрэмжлүүлэг тараах материал тараан ажиллалаа.

Мөн 7 өртөө зангилаадын 2569 ажилчдад СЭМҮТ-ийн сургагч багш,эмч Ж.Гантулгаар “Архи тамхи хор хөнөөл, Зөв хандлага,дадал зуршил” “Ажлын байран

дахь архидалт, Стресс менежмент” сэдвээр сургалт, Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг оролцогчдод заасан.

“Хяналт шалгалт-9” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Дархан өртөөн дээр гар дээрээс хууль бусаар спирт найруулан архи үйлдвэрлэн борлуулдаг иргэн С.Сэржидмаа,С.Пүрэвсурэн нараас 13 шил архи хураан авч Захиргааны хэрэг бүртгэгч ахлах дэслэгч Т.Энхтүвшин холбогдох хууль тогтоомжийн дагуу 50000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

Саатуулах байранд 2016 онд 3-аас дээш саатуулагдсан 17 эмэгтэй иргэнг мэдээллийн санд бүртгэл судалгаанд хамруулсан.

Хэрэг бүртгэгч ахлах дэслэгч Ж.Гэрэлтод, Ахлах байцаагч, цагдаагийн ахмад Д.Өнөртөгстэй хамтран ТЗДС,МСҮТөвийн 245 багш,оюутнуудад СЭМҮТ-ийн сургагч багш,эмч Ж.Гантулгаар “Архи тамхи хор хөнөөл, мансууруулах бодисын хэрэглээ -хор уршиг”, Тээврийн дээд сургуулийн дотуур байрны 52 оюутанд “Архи- гамт хэрэг,захиргааны зөрчил” -ийн талаар сургалт зохион байгуулсан. Газрын мэдээлэл сургалтын цагаар СЭМҮТөвийн эмч Ж.Гантулгаар “Эерэг хандлага зөв дадал зуршил” сэдвээр сургалт зохион байгуулсан.

УБТЗ-ын Тасалбарын төвийн хүсэлтээр 60 ажилчдад, Нийслэлийн галт тэрэгний зорчигч үйлчилгээний төв буудлын 21 ажилчдад 2 удаа СЭМҮТөвийн сургагч, их эмч Ж.Гантулгатай хамтран архины хор холбогдол, захиргааны зөрчлийн талаар мэдээлэл өгч ажилласан.

Газраас зохион байгуулсан “Тэнэмэл” арга хэмжээний хүрээнд 2016 оны 11 сарын 16-17 нд х/ч Цэрэндорж, х/ч Хаянгарав нарын хамт Төмөр замын нэгдсэн эмнэлэг, Ахмадын өргөө, ТЗУГ-ын орчим байрладаг 13 дулааны худгийг шалгаж илтгэх хуудсаар танилцуулан ажилласан.

2016 оны Сонгуулийн өдрөөр 6 сарын 29,30-нд архи согтууруулах ундаа худалдах борлуулахгүй байх УБХотын ЗД-ийн захирамжийн хэрэгжилтийг хангах үүднээс төмөр замын соёлын ордонд байрлах Мотив караоке,Ган зам хугацаатай албан мэдэгдэл өгч хариуг авч ажиллалаа.НХЖХТ-аас зохион байгуулсан “Зөрчлийн илрүүлэлт” ерөнхий арга хэмжээний салбар төлөвлөгөөний дагуу 2016.11.28-29 нд ЗАСТТхуулийн хэрэгжилтийг Төмөр замын Тасалбарын төвийн VIP ROOM, Нийтийн хоолны төвийн вокзалын ресторан, 103,106-р вагон ресторан, Кофе лоунж зэрэг байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж сэрэмжлүүлэг, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах талаар зааварчилгаа зөвлөгөө өгч ажилласан. Орон нутгийн давтан явагдсан Сонгуулийн өдрөөр 9 сарын 19,20-нд Төмөр замын архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг тасалбарын төвийн Vip room,вокзалын түрээсийн кофе лоунж, вагон рестораны үйл ажиллагаанд хяналт тавьж батлагдсан цагийн хуваарийн дагуу ажиллах үүрэг өгч, архи согтууруулах ундаа худалдах борлуулахгүй байх УБХотын ЗД-ийн захирамжийн хэрэгжилтийг хангах үүднээс 5 хугацаатай албан мэдэгдэл өгч, хяналт тавьж ажиллалаа.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахаас сэргийлэх чиглэлээр УБТЗ-ын харьяа вокзалын ресторан, Тасалбарын төвийн VIP ROOM

,Нийтийн хоолны харьяа УБ-Замын үүд чиглэлийн 103,104,106-р вагон рестораны үйл ажиллагаанд 10 удаа хяналт тавьж АСТТХ-ийн санамж хадах зааварчилгаа өгсөн.

Албадан эрүүлжүүлэгдсэн 2430 иргэний гар, хурууны хээ болон зургийг Шүүх шинжилгээний папилон санд оруулж бүртгэл судалгаанд хамруулан ажилласан.

2016 онд саатуулагдсан 2430 иргэнд архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг, зөвлөмж 200 ширхэгийг тараан, “Архины хор нөлөө, эмэгтэйчүүдийг эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?” сэдвээр өдөр бүр яриа таниулга хийж, эрүүл мэндийн зөвлөгөө болон хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Саатуулагдсан иргэдийн картыг өдөр тутам авч төлбөр төлөлт хугацаандаа төлөгдсөн эсэх , саатуулагдсан иргэдэд зарцуулсан эм тарианы зарцуулалтыг 4 удаа тооллого хийлгэн, Монос ХХК-аас 370000 төгрөгний эм тариа орлогод авч тайлан мэдээг сар болгон гарган санхүүтай тулган ажилласан.

Газрын алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 9 сарын 12 - 16 ны хооронд 80%-ийг хамруулж, Төмөр замын нэгдсэн эмнэлгээс лаборант авчирч 119 алба хаагчдын цусны шинжилгээг авахуулсан.

Төмөр замын эмнэлэгтэй хамтран газарт дээр Улаанбурхан улааны эсрэг вакциныг 15 алба хаагчийг хамруулан тарьсан.

ТЗНЭмнэлгээс дотрын эмч Булгантамир, хоол зүйч Хулангаа нар ирж газрын 65 алба хаагчдад элэгний өвчлөл, зөв хооллолтын талаар яриа сургалт мэдээлэл өгсөн.

ТЗНЭмнэлгээс эмч Насантогтохтой хамтран 2016 оны 10 сарын 24 нд 65 алба хаагчдад элэгний “В” вирусийн эсрэг вакцины нэг дэх тунг, 11 сарын 28-нд элэгний “В” вирусийн эсрэг вакцины хоёрдох тунг газрын 95 алба хаагчдад, элэгний “С”, “В” вирус илрүүлэх сорил шинжилгээг 31 алба хаагчдад тус тус хийлгэсэн.

ЦЕГ-ын Сургалтын төв дөөр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах нь” модуль сургалтанд 1 алба хаагч, УБЦГ-аас зохион байгуулсан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмч нарын сургалтанд 4 эмч хамрагдсан.

Эм импекс концерны эмч төлөөлөгч нараар эмийн зохистой хэрэглээний талаар газрын 68 алба хаагч нарт, саатуулах байрны 3 эмчид архины дуршил бууруулах эмийн хэрэглээний талаар тус тус сургалт зохион байгуулсан.

Саатуулах байранд шаардлага хангахгүй хуучирсан байгаа дэвсгэр даавууг солих хүсэлт гарган 2016.11.18-нд Дүүхээ төвөөс 15 ширхэгийг 330000 төгрөгөөр худалдан авч шинэчлэн иргэдэд үйлчилж байна.

Саатуулах байрны орчин нөхцлийн үнэлгээг гаргуулахаар Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын газарт хүсэлт тавьж ажлын байрны агааржуулалт, гэрэлтүүлэг, агаарын чийгшил тодорхойлсон дүгнэлт гаргуулсан.

Саатуулах байранд сүүлийн үеийн IP системийн 14 камерын хяналтын иж бүрэн төхөөрөмжийг шинэчлэн тавьсан.

Малчдад туслах аянд саатуулах байрны алба хаагчид идэвхитэй оролцон нэмнээ, лаа шүдэнз хандивласан.

Замын цагдаагийн хэсгээс:

Монгол Улсын Хууль зүйн сайд, Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн алба, Нийтийн хэв журам хамгаалах газар, Газар болон тасгийн дарга нараас өгсөн үүрэг даалгавар, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг хэрэгжүүлэх чиглэлээр тус цагдаагийн газрын Замын цагдаагийн хэсгээс 2016 онд доорхиажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэг:Осол зөрчлийн талаар

2016 онд гудамж замд хуваарийн дагуу 3 офицер, 6 зохицуулагч ажиллаж, нийт 10565зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 10380хүнийг 273,879,600 төгрөгийн бэлэн бус хэлбэрээр торгож,эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 85, согтуугаар автомашин жолоодсон 177 зөрчил илрүүлэн БГД-ийн замын цагдаагийн тасагт, цагдаагийн нийтлэг үүргээр гарал үүслийн бичиг баримтгүй мах, махан бүтээгдэхүүн, түүхий эд тээвэрлэж явсан 4, ASAP сангаар эрэн сурвалжлагдсан 4зөрчил тус тус илрүүлэн цагдаагийн газрын ерөнхий жижүүрт шилжүүлж ажиллаа.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу улсын дугаарын хязгаарлалтын хүрээнд хяналт шалгалт хийж 1398 зөрчил илрүүлэн бэлэн бусаар зөрчил гаргасан 1398 хүнийг 11,184,000 төгрөгөөр торгож ажил, амралтын өдрүүдэд хяналт тавьж ажилласан.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол мэдээлэл 123, зам тээврийн осол 6 хүлээн авч шалган мэдээлэл тогтоогдоогүй 2,харъяаллын дагуу шилжүүлсэн 1, жолооны эрх хассан 3, шийтгэврээр 123 хүнийг 6,124,600 төгрөгөөр торгож хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэлээ.

Төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудлын авто зогсоол дээр гарсан зам тээврийн ослын дуудлага мэдээлэл 6 хүлээн авч, ослын хохирлыг даатгалын байгууллагаар төлүүлж хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн.

Төмөр замын гарам дээр 2016 оны жилийн байдлаар 6 зам тээврийн осол гарч 1 хүний амь нас хохиорч, 4 хүний биед хүнд, хөнгөн гэмтэл учирч, иргэн, аж ахуй нэгжид 3,453,657 төгрөгний хохирол учирсан байна.

Хоёр: Осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр

Төмөр замын байгууллагууд орон нутгийн цагдаагийн байгууллага, алба хаагч нартай хамтран “Сар шинэ”, “Шалгалт”, ”Хөдөлгөөнт эргүүл”, “Төмөр замын гарам”, “Зогсоол”, “Оюутан тээвэр”, “Оюутан тээвэр-1“,“Хамгаалах бүс-Хамгаалалтын суудал”, “Тусгай дуут болон гэрэл дохио”, “Шинэ жил” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, “Замын хөдөлгөөний соёл–Бидний оролцоо”, “Хамгаалах бүс-Хамгаалалтын суудал”,“Мэдээлэл сурталчилгааны галт тэрэг”, “Гармын мэдлэг дээшлүүлэх” олон улсын өдөрлгийг Улаанбаатар төмөр зам, Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагуудтай хамтран зохион явуулж үр дүнг тооцож ажилласан.

УБТЗ-ын Хяналтын алба, Авто тээврийн газар, Замын цагдаагийн алба, Нийслэлийн нийтийн тээврийн газар, Нийтийн тээврийн ажил үйлчилгээ эрхэлдэг 20 аж ахуй нэгжийн дарга удирдах албан тушаалтан нартай хамтран“Аюултай бүсийн дэглэм”, “Төмөр замын гарам – Аюулгүйн бүс 1,2” сэдэвт зөвөлгөөнийг төмөр замын удирдах газрын зааланд зохион явуулсан.

Улаанбаатар төмөр замын Хүүхдийн байгууллагатай хамтран Төмөр замын цэцэрлэгүүдийн дунд Замын хөдөлгөөний “Цагаан толгой”–2016 тэмцээнийг удирдамж төлөвлөгөөний дагуу үе шаттай зохион байгуулж, 1 дүгээр шатны тэмцээнээс Улаанбаатар төмөр замын “Ган-зам “ цэцэрлэг шалгаран Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож 3-р байранд шалгарч шагнагдсан. Тэмцээний төсөв зардалд 1,400,000 төгрөг зарцуулсан.

Улаанбаатар төмөр замын Хяналтын алба,Замын анги, Дохиолол холбооны анги, Эрчим хүчний ангиудтай хамтранУлаанбаатар хот дотор байрлах төв болон, салбар замын гармуудын, Орон нутгийн цагдаагийн газар, газрыналба хаагчид, цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нартай хамтран төмөр замын хаалттай ба хаалтгүй гармуудын дохиолол, автозамын тэмдэг тэмдэглэл, гэрэл гэрэлтүүлэг, хяналтын камерын систем, элс, давс, хаалт хашилт стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд 8-н удаа үзлэг шалгалт хийж нөхцөл байдлын танилцуулгыг Улаанбаатар төмөр замын дарга болон Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан орлогч даргад албан бичгээр, төмөр замын ангиудад заагдсан зөрчил дутагдлыг засуулах чиглэлээр тухай бүракт тавин засуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажилласан. Ази-Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын зочид төлөөлөгчдийн явах маршрутанд байрлах төмөр замын 6-н гармын 34 ширхэг авто замын тэмдгийг шинчлэн байрлуулсан.

Улаанбаатар төмөр замын тээврийн хэрэгсэлтэй 33 аж ахуйн нэгж, албан байгууллагуудын тээврийн хэрэгслүүдийн техникийн бүрэн бүтэн байдлыг 4,5,6 саруудад график хуваарийн дагуу шалган илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр засуулан ажилласан.Авто тээврийн үндэсний төвтэй хамтран төмөр замын байгууллагуудын тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношлогоонд цаг хугацаанд нь хамруулан ажилласан.

Төмөр замын гармуудын аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр төмөр замын Хяналтын албатай хамтран хяналтын камерын судалгаа гаргажУлаанбаатар төмөр замын даргад саналаа хүргүүлж 407-р км/ийн гармыг хяналтын камераар камержуулсан.

Осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Улаанбаатар төмөр замын Замын анги, Дохиолол холбооны анги, Эрчим хүчний ангиуд, Авто бааз, ЗҮТБуудал, Зам засварын машинт станц, Улаанбаатар төмөр замын Татах хэсэг, Хүннү конгрей ХХК, Улаанбаатар Цахилгаан түгээх ТӨҮГ, нийтийн зорчигч тээврийн Эрдэм транс ХХК, Автобус- 5 ХХК, Автобус нэгтгэл, Хараацайн жигүүр ХХК, ЭМСИД ХХК, НЧБ ХХК, Сутайн буянт ХХКзэрэг байгууллагуудын жолооч нарт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар 26 удаа 31 цагийн сургалт зохион байгуулж, сургалтанд 85 байгууллагын 1985 жолооч, инженер техникийн ажилтан, гармын жижүүр хамрагдсан.

Төмөр замын гарам дээр гарч байгаа зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Улаанбаатар төмөр замын Ган зам сонинд 4 удаа нийтлэл,MNC телевизээр иргэд жолооч нарт 6 удаа сэрэмжлүүлэг, Шотг фэйс бүүк хуудсанд 12 удаа

сэрэмжлүүлэг, Зорчигч үйлчилгээний төв буудлын хажуугийн лед дэлгэцээр иргэд жолооч нарт өдөр бүр шторк, “АНХААР ЗОГС ГАЛТ ТЭРЭГНЭЭС БОЛГООМЖИЛ”, “ЯВГАН ЗОРЧИГЧ, ГАЛТ ТЭРЭГ АЮУЛТАЙ БҮС”, “ЖОЛООЧ, ЗОГС, ХАР, СОНС, ХҮЛЭЭ” зурагт санамж 9136 ширхэгийг иргэд жолооч нарт таралаж ажилласан.

ТЗЦГ-ын гадаах 40 автомашины зогсоол, Улаанбаатар төмөр замын өртөө, Зорчигч үйлчилгээний төв буудлын арын 160 автомашины зогсоолын дэг журмыг хангуулах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, түгжрэл саатлыг бууруулах, стандартын дагуу тэмдэгжүүлж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажилласан.

Улаанбаатар төмөр замын Зорчигч үйлчилгээний төв буудал болон орчмоос хөдөө орон нутагт зохих зөвшөөрөлгүйгээр зорчигч тээвэрлэсэн 17-н жолоочийн бичиг баримтыг арга хэмжээ тооцуулахаар Авто тээврийн үндэсний төвд, Нийслэлийн тээврийн газарт 1 жолоочийн бичиг баримтыг тоотоор шилжүүлж, 28-н жолоочид дахин энэ төрлийн зөрчил гаргуулахгүй байх талаар сануулж туслах тоо бүртгэлийн санд оруулж шийдвэрлэсэн.

Төмөр замын авто тээвэр үйлчилгээний төв, Олон улсын галт тэрэгний тасалбар түгээх төв зэрэг байгууллагуудын алба хаагч, жолооч нарт цагдаагийн газрын 2015 онд хийсэн ажлын тайлан болон осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар яриа хийж санал хүсэлтийг авч ажилласан.

Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 52 байгууллагад албан мэдэгдэл шаардлага өгч 31 байгууллагаас хариу авч ажилласан.

Ази-Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын үеийн зочин, төлөөлөгч нар манай улсад төрийн айлчлал хийх үеийн А зэрэглэлийн хамгаалалт,Нийслэлийн Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт зохиогдсон Шинэ оны нар харах арга хэмжээ, МУ-ын УИХ-ын сонгууль, Үндэсний их баяр наадам, БНХАУ, ОХУ-ын төмөр замын дарга нар Улаанбаатар төмөр замын ажил байдалтай танилцах, Монгол Оросын хувь нийлүүлсэн нийгэмлгийн 67 жилийн Мэргэжлийн өдөрлөг,Транс Сибирын зочин төлөөлөгчийнхамгаалалт зохицуулалтанд давхардсан тоогоор 3 офицер, 6 зохицуулагч 1389 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажилласан.

Замын цагдаагийн газраас ирүүлсэн гарам дээр засвар хийх үеийн аюулгүй байдлыг хангаж ажиллах хуваарийн дагуу Улаанбаатар төмөр замын 452, 407, 413, 396, 384-р км/ийнГовь, Хүр,Том холбох, Улаанбаатар импексийн гармууд дээр зам засварын ажил хийгдэх үед 2 офицер, 6 зохицуулагч цагдаа ажиллаж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж зохицуулалт хийж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын дарга, дэд комиссар Ц.Ням-Очирын өгсөн үүрэг, ажлын чиглэлийн дагуу алба хаагчдад бичгээр 19 удаа, Тээврийн прокурорын газрын 2016.03.31 өдрийн 04 тоот албан шаардлагын дагуу цагдаагийн газрын хэрэг бүртгэх эрх бүхий хэсгийн төлөөлөгч, хэв журмын байцаагч захиргааны хэрэг шалгах эрх бүхий 18 алба хаагчид 2 удаа зааварчилгаа өгч өдөр тутам хяналт тавьж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу газрын нийт алба хаагчдаас алба ба амины тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодохгүй байх талаар 4 удаа баталгаа авч ажилласан.

Улаанбаатар төмөр замын дагуух нутаг дэвсгэрт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, “Бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах журам”–ыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар төмөр замын санхүүжилтээр бэлэн бусаар торгох төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэгч “Соверейн ХХК”-аас 8,217, 000 төгрөгийн үнэтэй “Полисе Ридер“ иж бүрэн торгох төхөөрөмж багаж 2 ширхэгийг худалдан авч алба хаагчдыг хангаж, замын хөдөлгөөнд оролцохдоо зөрчил гаргасан жолооч нарт арга хэмжээ тооцохдоо чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.